

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 20/01

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсгийг удирдлага болгон Бодь даатгал ХК-ийн 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2020 оны 09 сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Бодь даатгал ХК-ийн 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1-т заасны дагуу баталсугай.
2. Бодь даатгал ХК-ийн 2020 оны хоёрдугаар хагасын бизнес төлөвлөлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.ЗОЛБАЯР

“Бодь даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
хурлын Тогтоол №20/01-ийн Хавсралт №1



Санхүүгийн байдал үйл ажиллагааны талаарх дүгнэлт

“Бодь Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

Санхүүгийн үзүүлэлт: Сүүлийн 3 жилийн дунджаар даатгалын салбарын цэвэр хураамж 19%, Бодь даатгалын цэвэр хураамж 27% өссөн байна. Харин, 2020 оны эхний хагас жилээр өмнөх оны мөн үеэс даатгалын салбар -0.5% буурч, Бодь даатгал +5.3% өссөн байна. Улмаар цэвэр хураамжийн орлогоор зах зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар нэмэгдэж 11.9% болсон байна.

Хагас жилийн байдлаар нийт цэвэр хөрөнгө болон мөнгөн хөрөнгийн өсөлтөөс үүдэн төлбөрийн чадварын үзүүлэлт 30 нэгжээр нэмэгдэж 130% болсон. Хагас жилд цэвэр ашиг 756 сая гарсан нь жилийн эцсийн цэвэр ашгийн төлөвлөлтийн 50%-д хүрээгүй байна.

Даатгалын үйл ажиллагаа: Бизнес төлөвлөгөөний дагуу 4 шинэ бүтээгдэхүүн хөгжүүлж, 8 онлайн бүтээгдэхүүн цахим хуудаст байршуулсан, цахим оффис нэвтрүүлэх ажлын эхний шат дууссан, үндсэн систем шинэчлэх гэрээ хийхэд бэлтгэсэн байна.

Дүгнэлт:

- Бодь даатгал ХК нь 2020 онд цэвэр хураамжийн зах зээлд эзлэх хувийг 1% нэгжээр нэмэгдүүлэх зорилгоос хагас жилийн байдлаар +0.7%-тай байна.
- Дунд хугацааны бизнес төлөвлөлтийн ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.
- Бодь даатгалын хамт олон төлөвлөгөөний дагуу, хэвийн ажиллаж байна гэж үзэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 20/02

Улаанбаатар хот

Компанийн дүрмийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсгийг удирдлага болгон 2020 оны 09 сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Бодь даатгал ХК-ийн Дүрмийг хавсралт №1-т заасны дагуу баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, дүрмийг Санхүүгийн зохицуулах хороо, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал / Б.Золбаяр /-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ЗОЛБАЯР

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 20/03

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дэх хэсгийг удирдлага болгон 2020 оны 09 сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Бодь даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:
 - Лувсандандан овогтой Болдхуяг
 - Ширчин овогтой Сүхбаатар
 - Ганбаатар овогтой Саруул
 - Болдхуяг овогтой Билэгт
 - Шонуунорсон овогтой Бэжид
 - Данзан овогтой Даянбилгүүн нарыг сонгохыг зөвшөөрсүгэй.
2. Бодь даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 - Эрдэнэ овогтой Бямбажав
 - Батаа овогтой Эрдэнэбат
 - Батчулуун овогтой Бүжинлхам нарыг сонгохыг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.ЗОЛБАЯР

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 20/04

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлыг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах хэсгийг удирдлага болгон 2020 оны 09 сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:


1. Бодь даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг хавсралт №1-т заасны дагуу баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ЗОЛБАЯР

“Бодь даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
хурлын Тогтоол №20/04-ийн Хавсралт №1



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

2020 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн зардлыг дараах байдлаар тогтоов.

№	Зардлын төрөл	Сарын зардал	Нийт зардал
1	ТУЗ-ийн ердийн гишүүдийн цалин	500,000	36,000,000
2	ТУЗ-ийн хараат бус гишүүдийн цалин	700,000	25,200,000
	Нийт зардал	1,200,000	61,200,000